



**ТАХЬКО (ХК) КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Ж.Самбуугийн гудамж-18, УБД 9010001029

Утас: 976-11-324738, Факс: +976-11-325051

И-мэйл: info@takhico.mn, Веб хуудас: www.takhico.mn

2020.04.15 № 14

танай _____ -ны № _____ -т

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ (ХК)
КОМПАНИД**

**Ээлжит хурал хуралдуулах
тухай**

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18, компанийн МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдуулахаар шийдвэрлэсэн билээ.

Энэ цаг үед дэлхийн хэмжээнд COVID-19 шинэ коронавирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Монгол улсын Засгийн газраас шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорионы онцгой дэглэмийг тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ныг дуустал хугацаанд сунгаж, онцгой нөхцөл байдал үүссэн тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулахаар болсныг Хөрөнгийн биржийн цахим хуудсанд мэдээлж өгөхийг хүсье.

Хувийг: Санхүүгийн зохицуулах хороонд

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Л.БУЯНБАТ

СОНИНЫ 11 УДИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Хэн сэтгэж байна, түүнд зориулав



8 658000 157525

"Монгол Ньюс" медиа групп

ӨНӨӨДӨР

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ СОНИН

2020.04.15 ЛХАГВА №075 (6877) Үнэ 10

Дугаарыг эрхэлсэн Гансүхийн ЦОЛМ

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛЦ

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 20-ны шийдвэрээр тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны 10:00 цагт компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18, компанийн МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдуулахаар шийдвэрлэсэн билээ.

Энэ цаг үед дэлхийн хэмжээнд COVID-19 шинэ коронавирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорионы онцгой дэглэмийг тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ныг дуустал сунгаж, онцгой нөхцөл байдал үүссэн тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийг 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байрны 308 тоот өрөөнд ирж ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөх боломжтой бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах чиглэлээр ажиллах болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр онлайн орчинд зайны технологийг ашиглан зохион байгуулахтай холбогдуулан шаардлагатай мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудсаар мэдээлэх бөгөөд хурал зохион байгуулахтай холбоотой асуудлаар хурал зохион байгуулах комисс болон компанийн 976-11-325051, info@takhico.mn хандаж болно.

ТАХЬКО (ХК) КОМПАНИ